



**ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

23119 Хэнтий аймаг, Хэрлэн сум, Сариг баг
Утас: 70-56-21-47, Факс: 70-56-21-12
E-mail: khentii@audit.gov.mn

2018.03.03 № 06/82

танай _____ -ны № _____ -т

Г **Аудитын гэрчилгээ** Г

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8.9.1-д заасны дагуу Хэрлэн сумын Өлзийт тосгоны захирагчийн ажлын албаны 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Хязгаарлалттай санал дүгнэлт

Аудитын гол асуудалд дурдсан алдаа зөрчлийг эс тооцвол Хэрлэн сумын Өлзийт тосгоны захирагчийн ажлын албаны 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул хязгаарлалттай санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Хэрлэн сумын Өлзийт тосгоны захирагчийн ажлын албаны 2017 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Аудитын гол асуудал

Бараа материалын дансны үлдэгдлийг тулган баталгаажуулахад 18.7 сая төгрөгийн үлдэгдэл бүхий малыг тоолоогүй, төлийн орлого аваагүй, нас дэвшилт хийгээгүй, үндсэн хөрөнгийн дансны үлдэгдлийг тулган баталгаажуулахад 6.5 сая төгрөгийн барилга байгууламж, 10.9 сая төгрөгийн тавилга эд хогшилыг тоолж тооцоо бодоогүй нийт 36,1 сая төгрөгийн зөрчил илэрсэн нь оршин байх, эрх ба үүрэг, үнэн зөв байдал гэсэн батламж мэдэгдлүүдийг тус тус хангахгүй байна.


0600480

Үүрэг, хариуцлага

Хэрлэн сумын Өлзийт тосгоны захирагчийн ажлын алба нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭРДЭНЭБААТАР



**ӨЛЗИЙТ ТОСГОНЫ ЗАХИРАГЧИЙН
АЖЛЫН АЛБАНЫ 2017 ОНЫ
САНХҮҮГИЙН ТАЙЛАН**

Менежментийн захидал

Тэргүүлэх ач холбогдол №1 зүйлс:

Асуудал 1
 Нягтлан бодох бүртгэлийн талаар3
 Төсвийн зарцуулалтын талаар 4
 Дотоод хяналтын талаар.....5

Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илэрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналийн бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга Аудитын олон улсын стандарт болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Өлзийт тосгоны Захирагчийн ажлын албаны нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаархи бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдолтойгоос нь эхлэн эрэмбэлэн үзүүлэв.

Эрүүлэлт:

1. Нийгмийн даатгалын сангаас ажилтануудын хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмжид олгосон 1.6 сая төгрөгийг санхүүгийн үр дүнгийн тайланд тусгасан, мөнгөн гүйлгээний тайланд 0.25 сая төгрөгийн хөрөнгийн зардлыг тусгаагүй, төсвийн гүйцэтгэлийн тайланд батлагдсан хөрөнгийн эх үүсвэрийг 113.8 сая төгрөгөөр дутуу илэрхийлсэн, төсвийн гүйцэтгэлийг 40.9 мянган төгрөгөөр дутуу илэрхийлсэн нь эрх ба үүрэг, үнэн зөв байдал, оршин байгаа, толилуулга ба илчлэл тодруулга батламж мэдэгдлүүдийг тус тус хангахгүй байна.
2. Бараа материалын дансны үлдэгдлийг тулган баталгаажуулахад 18.7 сая төгрөгийн үлдэгдэл бүхий малыг тоолоогүй, төлийн орлого аваагүй, нас дэвшилт хийгээгүй зөрчил илэрсэн нь оршин байгаа, толилуулга ба илчлэл тодруулга, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.
3. Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдлийг тулган баталгаажуулахад 6.5 сая төгрөгийн барилга байгууламж, 10.9 сая төгрөгийн тавилга эд хогшилыг тоолж тооцоо бодоогүй нь оршин байгаа, толилуулга ба илчлэл тодруулга, эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Зөвлөмж:

1. Сангийн сайдын 2010 оны 388 тоот тушаалаар батлагдсан "Төсөвт байгууллагад мөрдөгдөх дансны нэгдсэн заавар"-ын холбогдох заалтыг мөрдөж ажиллах
2. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.2.2, 70.2.4 дэх заалтуудыг тус тус хэрэгжүүлж ажиллах
3. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 70.2.1 дэх заалтуудыг тус тус хэрэгжүүлж ажиллах

Эрсдэл:

НББ-ийн тухай хуулийг хэрэгжүүлэхгүй байх
Дотоод хяналтыг хангалтгүй хэрэгжүүлэх

Төсвийн захирагчийн харуу:

Тусуудал 2: Төсвийн зарцуулалт

Тэргүүлэх ач холбогдол №2

Эргүүлэлт:

1. Мөнгөн хөрөнгийн зардлыг түүвэрлэн шалгахад анхан шатны баримтын бүрдэл хангаагүй 333.0 мянган төгрөгийн зөрчил илэрсэн нь эрх ба үүрэг, үнэн зөв байдал, оршин байгаа батламж мэдэгдлүүдийг тус тус хангахгүй байна.
2. Цалингийн зардлыг анхан шатны баримтаас тулган баталгаажуулахад цалингийн зардлаас 243.9 мянган төгрөгийг байгууллагын цахилгааны зардалд төлсөн, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлаас 324.1 мянган төгрөгийн цалин төлсөн, цалингийн зардлаас 343.2 мянган төгрөгийн шимтгэлийн зардал төлсөн зэрэг нийт 911.2 мянган төгрөгийн зориулалт бус зарцуулалт хийсэн нь эрх ба үүрэг, үнэн зөв байдал, оршин байгаа, толилуулга ба илчлэл тодруулга батламж мэдэгдлүүдийг тус тус хангахгүй байна.

Зөвлөмж:

1. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 7 дугаар зүйл 7.1, 7.4, 7.5, 7.6, 7.7 заалтуудыг хэрэгжүүлж ажиллах
2. НББ-ийн тухай хуулийн 7 дугаар зүйл 7.1 "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно" гэсэн заалтыг хэрэгжүүлж ажиллах, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 "Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэсэн заалтуудыг хэрэгжүүлж ажиллах

Эрсдэл:

Төсвийн тухай хуулийг хэрэгжүүлэхгүй байх
Дотоод хяналтыг хангалтгүй хэрэгжүүлэх

Төсвийн захирагчийн харуу:

Эргүүлэлт:

1. Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг шалгахад дараа жилийн төсвийн төсөл, аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайланг тус тус хугацаа хоцроож мэдээлсэн нь эрх ба үүрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Зөвлөмж:

3. Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3, 6.1.5 гэсэн заалтуудыг бүрэн хэрэгжүүлж, мэдээллийг тогтоосон хугацаанд тогтмол үнэн зөв мэдээлж байх

Эрсдэл:

Дотоод хяналтыг хангалтгүй хэрэгжүүлэх

Төсвийн захирагчийн хариу:

МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДЛЫГ

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ч.ЭРДЭНЭБААТАР

АУДИТЫН МЕНЕЖЕР

Д.ОЮУНТУЯА

ХЭЛТГЭСЭН:

АУДИТОР

Ц.ХАТАНБОЛД

Огноо: 2018-03-03

142

**ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

ХЭНТИЙ АЙМГИЙН ӨЛЗИЙТ ТОСГОНЫ ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ 2017 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

Эмэлт мэдээлэл авахыг хүсвэл
араах хаягаар харилцана уу:

АБ-ын Тэргүүлэх аудитор
тас: 70562112
Хаяг: Khentii@audit.gov.mn

Аудитын менежер: Д.Оюунтуяа
тас: 70562147
Хаяг: otuya_099@yahoo.com

Аудитор: Ц.Хатанболд
тас: 70562147
Хаяг:

АБ-ын хаяг
Адрес: Хэнтий аймаг Хэрлэн
Ум 3-р баг АЗДТГ-ын байр
Хаяг хуудас:
hentii@audit.gov.mn

018 оны 02 дугаар сар

Аудитын тайлан

- Хавсралт 1: Агуулга
- Хавсралт 2: Аудитын гэрчилгээ
- Хавсралт 3: Менежментийн захидал
- Хавсралт 4: Аудит хийсэн санхүүгийн тайлан
- Хавсралт 5: Төсвийн гүйцэтгэлийн тайлан

ГҮҮЛГА

1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл
2. Байгууллагын хууль, эрх зүйн орчин
3. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа
4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн
5. Дотоод хяналт
6. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар
7. Шилэн дансны мэдээлэл
8. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар
9. Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар
10. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:
11. Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:
12. Анхаарал татахуйц бусад чухал асуудал
13. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд
14. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл
15. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
16. Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт

Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл:

Төсвийн тухай хуулийн 8.9.1, Төрийн аудитын тухай хуулийн 15.2.1 дэх заалтыг үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 18.2 дугаар зүйлд заасан бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймгийн Өлзийт тосгоны Захирагчийн ажлын албаны төсвийн 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд СА-2018/126/СТА-ТШЗ/ аудит хийлээ.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, төлбөрийн дагуу явуулав.

Хэнтий аймгийн Өлзийт тосгоны Захирагчийн ажлын албаны 2017 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт/УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан улсын төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн захирагч санхүүгийн тайлангаа УСНББОУС, түүнд нийцүүлсэн Сангийн газрын холбогдох журмууд, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, програм хангамжийн дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС-тай нийцүүлж материаллаг аргаар шалгах, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Хэнтий аймгийн Өлзийт тосгоны Захирагчийн ажлын албаны 2017 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудитыг 2018 оны 01 дүгээр сарын 25-аас 2018 оны 02 дугаар сарын 25-ныг хүртэл хийхээр төлөвлөн ТАБ-ын аудитор [Хатанболд хэрэгжүүлэв. /ТАБ-СТА-А-9/

Хэнтий аймгийн Өлзийт тосгоны Захирагчийн ажлын албаны төсвийн 2017 оны төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг 2018 оны 01 дүгээр сарын 19-нд ТАБ-д ирүүлсэн байна.

ТАБ аудитыг 2018 оны 2 дугаар сарын 23-наас 2018 оны 02 дугаар сарын 25-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2018 оны 02 дугаар сарын 28-нд байгууллагын дирдлагад гардуулна.

Байгууллагын хууль, эрх зүйн орчин:

Төсвийн захирагч нь Монгол улсын Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Хот тосгодын эрх зүйн байдлын тухай хууль, Төрийн болон орон нутгийн захиргааны тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Шилэн дансны тухай хуулиудын хүрээнд үйл ажиллагаа явуулж байна.

Тайлант онд санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг гол хууль, тогтоомжид өөрчлөлт оруулж байгаагүй байна.

Байгууллагын зорилго, үйл ажиллагаа:

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.1-д аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын ажлын албаны Тамгын газар байх бөгөөд дор дурдсан чиг үүргийг хэрэгжүүлнэ гэж тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд Өлзийт тосгоны Захирагчийн ажлын алба үйл ажиллагаа явуулж байна.

145

Дээрх зорилтыг хэрэгжүүлэхийн тулд Монгол Улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д "Төсвийн байгууллага нь түүний үйл ажиллагааг үр ашигтай удирдлагаар хангаж, ажлын үр дүнг хариуцах үүрэг бүхий төсвийн шууд захирагчтай байна" гэж заасны дагуу Хэнтий аймгийн Өлзийт тосгоны захирагч Төсвийн шууд захирагчийн үүргийг гүйцэтгэж байна. Төсвийн шууд захирагчийн төсвийг сумын төрийн сангаар хангуулан олгож байна

Төсвийн тухай хуулийн 16.5 дугаар зүйлд "батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн ерөнхийлөнг удирдах, зарцуулалтад хяналт тавих, батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах, байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах" гэж заасан байна.

Төсвийн захирагчтай холбоотой хууль эрх зүйн баримт бичгийг судалсан бөгөөд байгууллагатай холбоотой хуулиуд бүрэн хэрэгжиж байна.

Төсвийн захирагчийн үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд ТАБ-СТА-А-1 маягтад тодорхой тусгасан.

Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн:

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, СНББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Аудитаар Хэнтий аймгийн Өлзийт тосгоны Захирагчийн ажлын албаны 2017 оны анхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд дүгнэлт өгөх үүднээс төсвийн захирагчийн удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай гэрээний лэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд төсвийн дансдын дамжлалт эрсдэл болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, баримт ариг гүйлгээ ихтэй томоохон дансдад түүвэрчилсэн байдлаар аудитын 9 хяналтын горим, нарийвчилсан сорил гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Тухайн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад ТАБ-СТА-А-5-ын санхүүгийн үйл ажиллагаанд хэрэглэгдэх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг боловсруулан мөрдөн ажиллаж байна. Энэхүү бүртгэлийн бодлогын баримт бичиг нь УСНББОУС-тай нийцсэн байна.

Төсвийн захирагчийн санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, хянах, боловсруулах үйл ажиллагааг санхүүгийн програмаар боловсруулан санхүүгийн тайлан бэлтгэх аргачлалын дагуу санхүүгийн тайланг гаргасан байна.

Дотоод хяналт:

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хийсэн. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, түүнийг хэрэгжүүлэхээр гаргасан заавар, журмыг хэрэгжүүлж, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн үйл ажиллагааг бүртгэлийн програмаар боловсруулж байгаа бөгөөд байгууллагын дотоод хяналтын эрсдлийн төлөвлөлтийн үед бага гэж тооцсон ба дахин хянахад дотоод хяналт хангалтгүй байна.

Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар:

Батлагдсан төсвийг хуваарийн дагуу Хэнтий аймгийн төрийн сангийн харилцах хургаар дамжуулан санхүүжүүлснээс гадна төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулах, гүйцэтгэлд хяналт тавин ажилласан байна.

Төсвийн захирагч нь 2017 онд улсын төсвөөс урсгал болон хөрөнгийн зардалд 133,6 сая төгрөгийн санхүүжилт авчээ. Үүнээс урсгал зардалд 133,5 сая төгрөгийг зарцуулж, батлагдсан төсвийг 0,1 сая төгрөгөөр хэмнэсэн байна.

Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6-р зүйлд заасан дараа жилийн төсвийн төсөл, аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайланг тус тус тугацаа хоцроож мэдээлсэн байна.

Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар:

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 9 эрсдлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр хяналтын болон нарийвчилсан нийт 9 горим, сорил гүйцэтгэв.

Үр дагаварыг тодорхойлж чадвал: Нийгмийн даатгалын сангаас ажилтнуудын төлбөрийн чадвар түр алдсаны тэтгэмжийг санхүүгийн үр дүнгийн тайланд тусгасан, мөнгөн гүйлгээний тайланд хөрөнгийн зардлыг тусгаагүй, төсвийн гүйцэтгэлийн тайланд батлагдсан хөрөнгийн эх үүсвэрийг зөрүүтэй илэрхийлсэн, бараа материал, үндсэн хөрөнгийн үлдэгдлийг бүрэн тоолж баталгаажуулаагүй, цалингийн зардлаас нийгмийн даатгалын шимтгэлийн зардал, байгууллагын цахилгааны зардлыг төлсөн, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлаас цалин төлсөн, анхан шатны баримтын бүрдэл хангаагүй баримтаар гүйлгээ хийж нягтлан бодох бүртгэлд тусгасан зэрэг зөрчил илэрсэн нь санхүүгийн тайлангийн оршин байгаа, эрх ба үүрэг, үнэн зөв байдал, толилуулга ба илчлэл тодруулга гэсэн батламж мэдэгдлүүдийг тус тус хангахгүй байна.

Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар:

Төсвийн захирагчийн 2017 оны санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцоолуудыг түүвэрчлэн нарийвчилсан сорилын аргаар шалгалаа. /ТАБ-СТА-В-З/

Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Аудитын явцад материаллаг хэмжээний дараах алдаа илэрсэн байна. Үүнд:

1. Цалингийн зардлыг анхан шатны баримтаас тулган баталгаажуулахад цалингийн зардлаас 243.9 мянган төгрөгийн байгууллагын цахилгааны зардлыг төлсөн, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлаас 324.1 мянган төгрөгийн цалин төлсөн, цалингийн зардлаас 343.2 мянган төгрөгийн шимтгэлийн зардал төлсөн зэрэг нийт 911.2 мянган төгрөгийн зориулалт бус зарцуулалт хийсэн

Шийдвэрлэсэн: Зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж өгөв.

2. Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдлийг тулган баталгаажуулахад 6.5 сая төгрөгийн барилга байгууламж, 10.9 сая төгрөгийн тавилга эд хогшилыг тоолж тооцоо бодоогүй

Шийдвэрлэсэн: Зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж өгөв.

- 149
3. Бараа материалын дансны үлдэгдлийг тулган баталгаажуулахад 18.7 сая төгрөгийн үлдэгдэл бүхий малыг тоолоогүй, төлийн орлого аваагүй, нас дэвшилт хийгээгүй

Шийдвэрлэсэн: Зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж өгөв.

4. Мөнгөн хөрөнгийн зардлыг түүвэрлэн шалгахад анхан шатны баримтын бүрдэл хангаагүй 333.0 мянган төгрөгийн зөрчил илэрсэн

Шийдвэрлэсэн: Зөрчлийг давтан гаргахгүй байх зөвлөмж өгөв.

5. Нийгмийн даатгалын сангаас ажилтнуудын хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмжид олгосон 1.6 сая төгрөгийг санхүүгийн үр дүнгийн тайланд тусгасан, мөнгөн гүйлгээний тайланд 0.25 сая төгрөгийн хөрөнгийн зардлыг тусгаагүй, төсвийн гүйцэтгэлийн тайланд батлагдсан хөрөнгийн эх үүсвэрийг 113.8 сая төгрөгөөр дутуу илэрхийлсэн

Шийдвэрлэсэн: Санхүүгийн тайланд залруулга хийв.

Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын

талаарх тайлбар:

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой 2 алдаа илэрсэн нь материаллаг бус санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөлөл байхгүй тул залруулга хийгдээгүй.

Анхаарал татахуйц бусад чухал асуудал:

Анхаарал татахуйц чухал асуудал үгүй байна.

Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд:

Хэнтий аймгийн Өлзийт тосгоны Захирагчийн ажлын албаны 2017 оны санхүүгийн айлангийн аудитын явцад гүйцээж мөшгин шалгаж амжаагүй эрсдэлтэй асуудал гараагүй байна.

Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:

Төсвийн захирагчийн 2017 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 153,0 сая төгрөгийн 6 алдаа, зөрчил илэрсэн ба 115,7 сая төгрөгийн алдааг санхүүгийн тайланд залруулга хийж, тооллого хийж тооцоо бодоогүй 36,1 сая төгрөг, зориулалт бус зарцуулалт илэрсэн 0,9 сая төгрөг, анхан шатны баримтын бүрдэл хангаагүй 0,3 сая төгрөг нийт 37,3 сая төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх талаар зөвлөмж өгөв.

Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт:

Төсвийн захирагчийн 2016 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд Хэнтий аймаг дахь Төрийн аудитын газраас түүвэрт хамруулж зөрчил илрээгүй тул зөвлөмж өгөөгүй байна.

Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт:

Хязгаарлалттай санал дүгнэлт

Нийгмийн даатгалын сангаас ажилтнуудын хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмжид олгосон 1.6 сая төгрөгийг санхүүгийн үр дүнгийн тайланд тусгасан, мөнгөн гүйлгээний тайланд 0.25 сая төгрөгийн хөрөнгийн зардлыг тусгаагүй, төсвийн гүйцэтгэлийн

даланд батлагдсан хөрөнгийн эх үүсвэрийг 113.8 сая төгрөгөөр дутуу илэрхийлсэн, 18.7 төгрөгийн үлдэгдэл бүхий малыг тоолоогүй, төлийн орлого аваагүй, нас дэвшилтэйгээгүй, 6.5 сая төгрөгийн барилга байгууламж, 10.9 сая төгрөгийн тавилга эд хогшилыг холж тооцоо бодоогүй, цалнгийн зардлаас 243.9 мянган төгрөгийн байгууллагын үхилгааны зардлыг төлсөн, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлаас 324.1 мянган төгрөгийн цалин төлсөн, цалингийн зардлаас 343.2 мянган төгрөгийн шимтгэлийн зардал төлсөн, анхан шатны баримтын бүрдэл хангаагүй 333.0 мянган төгрөгийн зөрчил илэсэн нь санхүүгийн тайлангийн оршин байгаа, эрх ба үүрэг, үнэн зөв байдал, толилуулга ба илчлэл тодруулга гэсэн батламж мэдэгдлүүдийг тус тус хангахгүй байна.


Дээрх алдаа зөрчлийг эс тооцвол Өлзийт тосгоны Захирагчийн ажлын албаны 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө, мөчлийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон илчлэл тодруулгад байлагдсан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн тайлангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, тодруулга илэрхийлэгдсэн байна.

Аудит хийгдсэн санхүүгийн тайлан 13 хуудас, хавсралтууд 4 хуудас, байгууллагын үйл ажиллагааны тайлан 1 хуудсыг тус тус хавсаргав.

Аудитын тайланг


Хянасан:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭРДЭНЭБААТАР

АУДИТЫН МЕНЕЖЕР




Д.ОЮУНТУЯА

Бэлтгэсэн:

АУДИТОР



Ц.ХАТАНБОЛД



Огноо: 2018.03.03